


БАТЛАВ.



**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ҮЕД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ОНОШЛУУР
НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар № 144

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Биомед Трейд ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээг (цаашид “бараа” гэх) 90,000,000 (ерэн сая) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

Барааны нэр, төрөл	Марк	Үйлдвэрлэгч, Улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
Коронавируст халдвар (COVID- 19)-ын хурдавчилсан оношлуур	COVID19 rapid test, 25ш/хайр	Core Technology Co.,Ltd БНХАУ	ширхэг	7500	12000	90 000 000
Нийт дүн						90 000 000

1. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг **90,000,000** (ерэн сая) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.
2. Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн оношлуурыг 2020 оны 05 дугаар сарын 11-ны өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
3. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Бусад шаардлагатай баримт бичиг¹;
 - Тендер ба үнийн хуваарь;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 - Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
 - Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
5. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
6. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

№	Барааны нэр, төрөл	Марк	Гэрээний нийт дүн /төгрөг/	Санхүүжих дүн 100% /төгрөг/
1	Коронавируст халдвар (COVID-19)-ын хурдавчилсан оношлуур	COVID19 rapid test, 25ш/хайр	90 000 000	90 000 000
	Нийт дүн			90 000 000

ГУРАВ. БАРААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Хуучны нэр	Барааны гарал үүсэл	Үйлдвэрлэгчийн нэр	Үзүүлэлт	Зураг
COVID-19 Шинэ савирусын халдварыг үүтэх тэвчилсэн	БНХАУ	CORE TECHNOLOGY CO.,LTD	Кассет хэлбэртэй, 10-15 минутанд хариу гарна. Сийвэн болон цусанд халдварыг байгаа эсэхийг тодорхойлно. 1 хайрцагт 25 ш савлагдсан, хайрцагт 25 ш өндөг цоологч, 1 ширхэг шингэлэгч уусмал, заавар багтана. CE шаардлага хангасан. БНХАУ-ын Чөлөөт худалдааны сертификаттай /Free Sales Certificate/	

Зохихлагчийг төлөөлж:

Ажлын хэлтсийн дарга:



Н.Гэрэлт-Од, ЭМЯ-ны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга

Бүрийн бичиг:



Т.Мөнхтуул, ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн

Ганшууд:



Г.Цэцэнсанаа, ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга



Б.Сансармаа, ЭМЯ-ны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын ахлах мэргэжилтэн



А.Баярсаяа, ЭМЯ-ны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын мэргэжилтэн



Э.Гэрэлмаа, ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн



Г.Догсмаа, ЭМЯ-ны ахлах нягтлан бодогч



Ж.Лхагважав, ЭМЯ-ны аж ахуйн менежер



П.Энхболор, ЭМЯ-ны нярав



Ж.Нямсүрэн, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгээс шалтгаалах дотоод халдварын тасгийн эрхлэгч



Б.Баярцэцэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эм зүйн албаны дарга

Нийлүүлэгчийг төлөөлж:

“Биомед Трейд” ХХК-иас
Ерөнхий менежер

Менежер



Г.Эрдэнэтунгалаг

Д.Маралмаа